

Номун 3.Түмэнжаргал

ХАР ҮРЭЭ,  
СААРАЛ ЧОНО. ХУНДАН ТӨЛӨГ,

ЖААЛХУУ

ДӨРВИЙН ТУУЖ

ЖУЧТЖ

**Номун 3.Түмэнжаргал**

**ХАР ҮРЭЗ, СААРАЛ ЧОНО, ХУНДАН ТӨЛӨГ,  
ЖААЛХҮҮ ДӨРВИЙН ТУУЖ**

Сургуулийн бага, дунд насынханд зориулав.

Зураач Аюурзанын Хайнбогд (6 нас)


Хянан тохиолдуулагч О.Мөнхтүяа  
Хэвлэлийн эх балтгасан Н.Хедэлмер  
Хянагч Ж.Гэрэлмаа



Хэвлэн нийтлэгийг Интерпрес ХХК

2007 он

## ОРШИ



Яасан хэцүү юм бэ дээ? Хүн байна гэдэг чинь шал дэмий юм. Яах гэж би хүн болж төрөв дөө... гэж бодохоос Жаалхүүгийн гол харлана. Ээж "Чи чинь ямар мал шиг хүүхэд вэ?" Хүний уг авна гэж ер байхгүй. Амьтны хүүхэд хичээл номдоо сайн сурч эцэг эхээс баярлуулаад л, гэрийнхээс ажил төрөлд нэмэр болоод л, хэл уг удах чихнээс хонх уяхгүй сайхан байх юм. Манай энэ л гэж яачихсан хүн бэ? Нуур царайных нь байж байгааг хараач. Газар доороос гараад ирсэн юм шиг... Хаалгаар шагайж цүнхтэй номоо чулуудчихаад л бараа сураггүй арилаад өгнө. Естой нэг тэнгэр нь хаясан хүүхэд" гэж баахан яншсан.

Хичээл дээр ангийн багш бас зөндөв зэмлэсэн. "Ганцхан чиний чихийг бөглөж байгаад би хичээл заагаа юу?" ч... гэх шиг. Бас цэвэрлэгч авгай юу гэлээ? "Энэ олон зуун хүүхдийн бүгдийнх нь гутлын шавхай нийлээд ганцхан чинийхэд хүрэхгүй. Дэндуу заваан жаал юм..." гэж загнасан.

Айлын хүүхдүүд зүгээр л инээд алдаад гүйж явах юм. Яасан сайхан юм бэ? Би л гэж дайралсан болгонд нуд үзүүрлэгдэж явах... Эмээгээс ондоо өмөөрх хүн ч байх биш. Яах ч гэж хүн болж төрөв дөө? Тэрийн оронд нэг сайхан морь болоод төрчихгүй. Хэрэв би морь болж төрсөн бол хэн ч намайг хичээл давтсангүй, гэрийн бараа харсангүй, шавхай чирлээ, энээ тэрээ гэж үглэхгүй сэн.

Ер нь ингэж байхаар гэв  
гэнэтхэн л морь болчих  
юм сан гэж бодов.



## НЭГ

Яг тэгж бодтол...

Яг тэгж бодтол жаалхүү морь болчков. Үнэхээр морь шүү.

...Жавхалсан сайхан хар үрээ болчкоод явж байхад нь хэн ч түүн үрүү "Хүүе, сургуульдаа орооч. Бас л хожимдчихлоо" гэж хашхирсангүй.

Өдөржингээ тэнэлээ. Ганцхан гэм нь хүүхдүүд шиг бөмбөг өшиглөж тоглохгүй нь... Гэвч тэр морь байрныхаа хүүхдүүдийн тоглохыг харх баахан зогслоо. Өөрийнхээ багийг хожигддогийн даваан дээр л бөмбөгийг нь булааж аваад негөө талын хаалга уруу хурдалчихмаар санагдаад болдоггүй. Гэвч морь хэзээ л хүүхдүүдтэй бөмбөг өшиглөж байлаа даа?

Тэгж байтал ээж нь тэнд хүрээд ирэв. Морь ч үхтлээс айлаа. "Одоо хары! Аяга шаазан угаа. Хог шүүрд..." гэх байх даа гэж зүрхшээн бодтол дэргэдүүр нь ажигч үгүй өнгөрөөд явчхав.

Одоо тэр жаалхүү биш морь юм чинь.

...Орой болохын алдад негөө хар үрээг нэг өвгэн барьж аваад явлаа.

Санаандгүй байтал шүү. Мэдсэн бол тэр баригдахгүй хулгих байсан юм. Гэтэл одоо хазаарлуулаад хөтлийлж явна. Өвгэн хашаанд орж өвс тавьж өгч байна. Өвсийг үнэрлэхээс өөр ях билээ? Харин ус нь зүгээр юм. Морийг түүхий ус уулаа, хоолой чинь өвдөнө гэж загнахгүй нь сайхан.



Гэтэл маргааш нь хэрэг биш  
болов.

Хар үрээг тэргэнд хөллөөш.  
Өнөөх өвгөн тэрэгний араУ  
дээр сандайлаад урт сураар  
шар хийтэл ороолгож байна.  
Хэцүү шуу. Тэгээд өдөржин тулзээ  
зөөлөө. Сүүлдээ ч бүр эцэж цуцахын  
түйлгүүзээ. Хашигнахаарташуурдана.  
Морийг тэгэлгүй ч яахав дээ.

Орой, бүр ч аймаар юм болов.

Түүний уруулыг цоровдон боож байгаад хөлд  
нь тах хадав.

Яг ул уруу нь хадаас шаана гэдэг аймар биз? Хар үрээ  
зэндөө уйллаа. Жаалхүү чигээрээ байсан бол ч орилоод, гүйгаад хэлэх сэн. Даанч  
морь болчихсон болохоор яахав дээ. Ямар ярьж чадах биш.

Тэгээд зогсоогүй ээ. Бас час улайтгасан тэмэр тамгаар ташаан дээр нь хиншүү  
хярvas ханхлуулан дарлаа. Ямар аймар гэж санана...

Хүн байх ч хэцүү юм. Морь байх бүр ч хэцүү юм. Яая даа? Яасан азгүй юм бэ? Ингэж  
байхын оронд чоно... Нээрэн чоно бол хамаагүй дээр. Яршиг зүгээр чоно  
болчих юм сан...



XOËP

Яг тэгж бодтол...

Яг тэгж бодтол, хар үрээ биш чоно болчхов. Сэргээ нь боссон зэгзгэр саарал чоно болчхоод үүл талаар явж байхад хэн ч түүнийг энээ тэрээ гэсэнгүй...

Барьж авч хазаарласангүй. Уянсангүй. Тэргэнд хөллөсөнгүй. Бас хөлд нь тах хадсангүй. Таашаан дээр нь тамга дарсангүй.

Ой тайгаар өдөржин тэнэлзээ. Харин хот орж хүүхдийн паркаар явж болдоггүй нь гонсоймоор. Гэлээ ч яахав. Яг явсаар нэг их бөөн моносон дотор орчихлоо. Бенжигнэсэн хар хар майл багсайгаад даанч гоё. Мойлыг амаараа шувт шутат татан илдээ. Гар байхгүй юм чинь.

Гэдсээ дүүртэд идээд модны захад гарав. Гэтээ... гэтээ яасан гэж бодно оо.

Чихнийх нь хажуугаар сум шүнгинан өнгөрөв. Яана аа?

Хар эрчээрээ зүглэлаа. Гэтэл өмнөөс нь хоёр улаан халтар нохой дүүлэн айсүй. Эзэн нь ард нь алаг морьтой давхиж харагдана. Хартал тэр алаг морьтой хүн жаалхүүгийн өөрийнх нь өвөө байлаа. Тэр өвөөгөө таниад гүйгээд очмоор санагдсан чоно болчихсон юм чинь ях билээ дээ. Яаж ойлгуулах билээ дээ? Буцаад зүглэлаа.


Балар ширэнгэн дундуур бултаж арай гэж амь мултрав.



Өлсөж байгаа  
гэж хачин. Нэгэн  
хадны харанхуй  
хонгилд орж  
хэвтээд тэр юм

бодлоо. Чоно байх ч, хун байх ч, аль аль нь шал дээмий юм. Ялангуяа чоно байна гэдэг бүр ч зовлонтой юм. Ясан азгүй юм бэ. Би юу болох вэ? Хорвоод хамгийн жаргалтай амьтан юу вэ?

Хашаа хотондоо амар хэвтээд л хивж байдаг хонь ч сайхан юм уу даа? Ер нь хонь болбол дээр байх. Хонь л болчих юм сан.



## ТУРАВ

Яг тэгж бодтол...

Яг тэгж бодтол саарал чоно биш махир эвэртэй хундан төлөг болчхов. Бэмбийсен хөөрхөн хундан төлөг болоход нохой ч хөөсөнгүй. Бууны сум ч шунгинасангүй. Хүн биш, морь биш, чоно биш, хонь юм чинь ёстой л сайхан байна.

Ж У Ч Т Ж

Шене хашаанд хэвтэнэ. Өдөр бэлчинэ. Ус ууна. Хааяа грийн шуулттай хаяагаар боорцог морцогхон олоод идчихнэ. Харин компьютерэр тоглож, бэмбэг өшиглөж, уул уруу самарт явж болохгүй нь хэцүү. Овоо аятайхан байж байтал бас л нэг өдөр болохоо болив. Ойрхон газар бэлчээзэдл орой нь аваачаад хашчихдаг хоньчин өвгөн тэр өдөр бүр хол тугаад явчихлаа. Эцэж туйлдтэл түүв. “Энэ одоо хашаа аваачих гэж ийм хол тугаад байна аа? Ямар балай юм бэ.” гэж төлөг бодов. “Бусад муусайн хонинууд юу ч болоогүй юм шиг л явах юм. Урьд нь хүн байж үзээгүй болоод тэр дээ” гэж бас бодов. Яваад л байлаа, яваад л байлаа. Тэгсэн чинь харин мах комбинат дээр ирдэг юм байна. Мах комбинатын сараалжин хашаа уруу түрүүчийг нь оруулж эхэллээ. Хонинууд ухзх гэж байгаагаа мэдэхгүй тэнэг царайлаад л дув дутгүй ороод байна. Эргэж зугтааяа гэтэл ямар ч арга алга. Одоо би хүн ч биш, морь ч биш, чоно ч биш, хонь ч биш элэгний нухаш юм уу, аяны зууш болно. Яана аа? Лаазлуулаад дэлгүүрт очно. Өнгөрлөө..? Эзж ээ, авв аа? Намайг аваач? гэж хашгирмаар. Гэтэл

хонь юм чинь яах билээ? Жаахан хундан төлөг  
мах комбинатын хаалганд ойртоосор л...  
Баларлаа, баларлаа. “Хүн болох



юм сан... Хамаагүй ээ бүр мүү, тэнэг ч хамаагүй хүн болох юм сан..." гэж бодно.  
Болдоггүй шүү. Хүн болдоггүй...

Морь бол्यё, чоно бол्यё, хонь бол्यё гэхэд тэр дорхноо л, бодмогц болоод байсан.  
Гэтэл яг хүн бол्यё гэхээр болдоггүй. Яасан заяагүй юм бэ? Заяа нь хая даа? Би  
хүн чигээрээ байж л байхгүй явав аа? Яана аа? гэж цухалдав. Хонинуудаас сугараад  
үлдчих санаатай хоцортол шилбүүр тасхийлээ. Хашаа уруу орлоо.  
Ингээд дууслаа...

Хундан төлөг нулимс цувгуулан уйллаа. Хашаагаар оронгутуут... Ура. Яасан их аз вэ?  
Өвдөг нь цоорхой жийнсэн өмдтэй, халтар нүүртэй сөөсийсэн жаал болоод хувирчих  
нь тэр ээ.

Хагартлаа баярлаад толгой өргөн харвал түрүүчийн шилбүүрдээд байсан хоньчин  
өвгөн гэнэт түүнийг олж үзээд,


-Хүүе, чи энд юу хийж явваа юм бэ? Гэртээ харь, миний хүү. Энэ муухай шавхай  
дотор яаж явваа юм бэ? Гар, гар гэлээ.

## ТӨГСГӨЛ

Бөөн баяр. Үхээд боссон хүн л ингэж  
баярлах байх даа.


Жаалхүү ганц ухасхийгээд  
хашаа даваад гүйчилгээ.

Тэр "Хүн байх яасан сайхан  
юм бэ? Хүн бүхнийг дийлдэг.



Хүн болж төрнө гэдэг ямар их аз вэ? Би хичээл номоо сайн давтаад, аав ээжийнхээ үгэнд ороод байхад зэмлүүлэх ч үгүй шүү дээ. Зэмлүүлсэн ч яахав. Одоо би ёстой жинхэнэ сайн хүн болно. Аав аа, ээж ээ, багш аа, цэвэрлэгч эгч ээ? Та нар намайг хараарай гэж баярлан бодлоо.

Тэгээд ижийт аавдаа очихоор хар эрчээрээ гүйн одов.



ЖҮЧТЖ

((  
8))





Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
"Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ)  
төсөл"-ийн хурээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно

